



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Эх орон намын дүрэм /Шинэчилсэн
найруулга/-ийг бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Э.Золзаяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Эх орон намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Г.Банзрагчийн илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Эх орон намын дарга Б.Эрдэнэбатаас “Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн намын мөрийн хөтөлбөр, дүрэмдээ өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцүүлэн батлуулж, хүргүүлж байна, зохих журмын дагуу хянан бүртгэж өгөхийг хүсье” гэсэн өргөдлийг нийт 77 хуудас баримт, 2 ширхэг флаш диск, 1 ширхэг сонины хамт 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн.

Дээрх өргөдөл, түүнд хавсаргасан баримтуудыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 2.5-д заасны дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлж, 2 удаа сонсох ажиллагааг хийсэн ба тухайн ажиллагааны явцад нэмэлтээр 3 удаа бичгээр тайлбар, 44 хуудас баримт ирүүлснийг шалгаад, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Эх орон намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг дараах үндэслэлээр бүртгэж шийдвэрлэлээ.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ” гэж заасан.

Эх орон намаас дээрх хугацаанд буюу 2024 оны 12 дугаар сарын 05, 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр “дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэх” өргөдлийг гаргасан байх бөгөөд Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 36 дугаар тогтоолоор “шийдвэр гаргах ажиллагаатай холбоотой баримт ирүүлээгүй, намын дүрэм Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцэхгүй” гэж, Улсын дээд шүүхийн 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 03/116 дугаартай албан бичгээр “Улсын дээд шүүхийн тогтоолд дурдсан зөрчил бүрэн арилаагүй, дүрмийн нэмэлт, өөрчлөлт хуулийн шаардлагад нийцээгүй” гэсэн үндэслэлээр бүртгэхээс татгалзаж шийдвэрлэсэн.

Тухайн нам нь 2026 оны 03 дугаар сарын 21-ний өдөр ээлжит бус Их хурлаа хуралдуулан намын дүрэмдээ өөрчлөлт оруулж, бүртгүүлэх тухай өргөдлийг 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Улсын дээд шүүхэд дахин гаргасан нь Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар “зөрчлөө зассаны үндсэн дээр дахин нэг удаа 60 хоногийн дотор хандах”-аар тогтоосон хугацаанд, мөн Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлнэ” гэсэн заалтад нийцсэн байна.

Нэг. Намын ээлжит бус Их хурлын тухайд:

Эх орон намын дүрэм (2016 он)-ийн 2.5.1-д “Намын төлөөллийн төв байгууллага - Бага чуулган нь Их хурлын чөлөөт цагт намын амьдралын гол чухал асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, а/-д “... ээлжит бус Их хурлыг Бага чуулганы гишүүдийн дийлэнх олонхын шаардлагаар зарлан хуралдуулна” гэж заасан байна.

Эх орон намаас 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 1/47 дугаартай албан бичгээр “... намын ээлжит бус Их хурлыг Эх орон намын 2005 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн Их чуулганаас баталсан “Ээлжит бус Их чуулганыг хуралдуулах журам”-ын дагуу намын ээлжит бус Их хурлыг зохион байгуулсан” гэх тайлбарыг журмын хамт ирүүлсэн ба уг журамд “Эх орон намын ээлжит бус Их чуулганыг зарлан хуралдуулахдаа энэхүү журмыг дагаж мөрдөнө” гээд 1 дэх хэсэгт “Эх орон намын ээлжит бус Их чуулганыг намын шинэчлэн баталсан дүрмийн 2.5.1-ийн “а” заасны дагуу Бага чуулганы гишүүдийн дийлэнх олонхын шаардлагаар зарлан хуралдуулна”, 2 дахь хэсэгт “Намын ээлжит бус Их чуулганыг хуралдуулах зарын дагуу хүрэлцэн ирсэн намын гишүүдийг төлөөлөгч гэж үзэх ба намын Их чуулганы төлөөлөгчийн бүрэн эрхийг эдэлнэ” гэжээ.

Эх орон намын Бага чуулганы 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар Бага чуулганы гишүүдийг шинэчлэн баталсан байх ба нийт 123 гишүүний гуравны хоёроос дээш буюу 83 гишүүнээс “... намын дүрэм, мөрийн хөтөлбөрийн өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд бүртгүүлэхтэй холбогдуулан намын ээлжит бус хурлыг яаралтай зарлан хуралдуулах ...” шаардлагыг 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Улс төрийн зөвлөлд хүргүүлсэн, тус зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 03/2026 дугаартай тогтоолын 1 дэх заалтаар ээлжит бус Их хурлыг 2026 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зарлан хуралдуулах, 5

дахь заалтаар ээлжит бус Их хуралд намын нийт гишүүдээ төлөөлөн оролцохоо илэрхийлсэн гишүүдийн саналыг аливаа хязгаарлалтгүй, нээлттэй, ил тод авч хуралд оролцуулан ээлжит бус Их хурлын төлөөлөгчдийг бүрдүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Эх орон намын дүрэм (2016 он)-д ээлжит бус Их хурлыг хуралдуулахаас өмнө товлон зарлах тодорхой хугацааг заагаагүй бөгөөд 2026 оны 03 дугаар сарын 21-ний өдөр хуралдах Их хурлын зарыг Өдрийн сонины 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн №031(7883) дугаарт нийтлэн нийтэд мэдээлснээр хуралд оролцох намын гишүүд, төлөөлөгчдийн эрхийг хангасан байна. Улмаар 2026 оны 03 дугаар сарын 21-ний өдөр танхимын хэлбэрээр зохион байгуулагдсан ээлжит бус Их хурлын 01 дүгээр тогтоолоор ажлын хэсэгт бүртгүүлсэн 98 гишүүний ирцийг баталж, төлөөлөгчдийн бүрэн эрхийг баталгаажуулсан нь өргөдөлд хавсарган ирүүлсэн 98 гишүүний гарын үсэг, холбогдох мэдээлэл бүхий ирцийн бүртгэл, намын гишүүдийн үнэмлэх, зураг, дүрс бичлэг зэрэг баримтаар тогтоогдсон, энэ нь намын дүрмийн 2.8.1-д “Оролцвол зохих гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр намын бүх шатны байгууллагын хурал хүчин төгөлдөр болно” гэж заасантай нийцжээ.

Хоёр. Намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийн тухайд:

2.1.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:” гээд, 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж, Эх орон намын дүрэм (2016 он)-ийн 2.4.1-д “Намын удирдах дээд байгууллага ... дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, а/ “намын мөрийн хөтөлбөр, дүрмийг хэлэлцэж батлан, тэдгээрт өөрчлөлт оруулна”, 2.8.2-т “Хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргана” гэж тус тус заасан.

Эх орон намын ээлжит бус Их хурал 2026 оны 03 дугаар сарын 21-ний өдөр хуралдаж, намын дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж, хуралдаанд оролцсон 98 төлөөлөгчийн 100 хувийн саналаар дэмжин баталсан нь Тооллогын комиссын 1 дүгээр тогтоол, ээлжит бус Их хурлын “Эх орон намын дүрмийн өөрчлөлтийг Улс төрийн намын тухай хуульд нийцсэн гэж үзэж баталсугай” гэж шийдвэрлэсэн 03 дугаар тогтоол, хурлын тэмдэглэл, дүрс бичлэг зэрэг баримтаар тогтоогдож байна.

Өргөдөл, түүнд хавсарган ирүүлсэн баримтуудаар “ээлжит бус Их хурлаар намын дүрмийн өөрчлөлтийг баталсан” гэх боловч Улсын дээд шүүхэд бүртгэлтэй Эх орон намын дүрэм (2016 он)-ийн 172 зүйл заалт буюу 95 хувьд нь нэмэлт, өөрчлөлт орсон байх тул намын дүрэм бүхэлдээ шинэчлэгдэн батлагджээ.

2.2.Эх орон намын дүрэм /Шинэчилсэн найруулга/ нь нийт 14 зүйл, 159 хэсэг, 22 заалт, 106 дэд заалтаас бүрдэх бөгөөд Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-15.2.10-т заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлагад нийцжээ.

Улсын дээд шүүхийн 2026 оны 03/116 дугаар албан бичигт заасан “Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 36 дугаар тогтоолд дурдсан “гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллагын хурлын товыг хэн, хэзээ, ямар журмаар

тогтоох, хурлын зарыг гишүүдэд хэзээ, хэрхэн яаж мэдэгдэх, шийдвэр гаргах журмыг нарийвчлан зохицуулаагүй” зөрчил бүрэн арилаагүй; намын төлөөллийн төв байгууллага болох Бага чуулганаас Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох, Бага чуулганы гишүүдийг нөхөн сонгохоор зохицуулсан нь буруу, намын удирдах дээд байгууллагад хадгалагдах онцгой бүрэн эрхийг төлөөллийн төв байгууллагад олгосон нь хууль зөрчсөн; хуулийн 37.8-д заасан шаардлагыг хангаагүй; намын даргыг чөлөөлөх, огцруулах үндэслэлийг тодорхой зохицуулаагүй; намын гишүүнээс түдгэлзүүлэх үндэслэл, үүнтэй холбоотой шийдвэр гаргах журам, намын анхан шатны салбар нэгжийг татан буулгах үндэслэл, журмын талаар намын дүрэмд тодорхой тусгах; намыг өөрчлөн байгуулсан, үйл ажиллагааг нь зогсоосон шийдвэр хүчин төгөлдөр болох, үүсэх үр дагаврыг журамлах, намын санхүүгийн асуудлыг хариуцсан дотоод аудиторын орон гарсан тохиолдолд түүнийг хэрхэн нөхөн томилох талаар намын дүрэмд тодорхой тусгах” зэрэг алдаа зөрчлүүд дараах байдлаар арилсан байна. Тухайлбал,

2.2.1. Намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийн 6.6-д ээлжит болон ээлжит бус Их хурлын зарыг ямар хугацааны өмнө хэрхэн гишүүдэд хүргэхийг, 7.6-7.8-д Улс төрийн зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдааныг ямар хугацаанд зарлан хуралдуулах, гишүүдэд зарыг хэрхэн хүргэхийг, 7.11-д шийдвэр гаргах журмыг зохицуулжээ. Мөн 8 дугаар зүйлд Удирдах зөвлөлийн, 10 дугаар зүйлд Хяналтын зөвлөлийн хурлыг товлон зарлах болон гишүүдэд хурлын зарыг хүргэх хугацаа, хэлбэр болон шийдвэр гаргах журмыг тус тус заасан.

2.2.2. Дүрмийн 5.5-д “Намын хяналтын байгууллага нь Хяналтын зөвлөл байх бөгөөд намын Их хурлаас байгуулна”, 6.8-д “Намын Их хурал дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ. Үүнд: б.Намын Хяналтын зөвлөлийг 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус 4 жилийн хугацаатай байгуулж, бүрэлдэхүүнийг нь сонгож батлах, чөлөөлөх, огцруулах, нөхөн сонгох, ...” гэж намын хяналтын байгууллагын бүрэлдэхүүнийг Их хурлаас сонгох хуулийн зохицуулалтад нийцүүлэн баталсан.

Харин дүрмийн 10.11-д “Намын хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөгдсөн тохиолдолд намын ээлжит бус Бага чуулганыг 60 хоногийн дотор зарлан худалдуулж, намын хяналтын зөвлөлийн гишүүнийг нөхөн сонгоно” гэж заасан нь тус намын дүрэмд намын бүтцийн аливаа байгууллагыг нэрлэн заагаагүй “Бага чуулган” гэх нэр томъёог ашигласан нь ойлгомжгүй байх боловч Эх орон намын дарга Г.Эрдэнэбатаас 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдөр “намын шинэчилсэн дүрмийн 5.4, 9.11, 9.12-т 2 удаа, 10.11-д “Их хурал” гэж бичих ёстойг “Бага чуулган” гэж андууран бичиж, техникийн шинжтэй алдаа гаргасан” гэсэн тайлбар ирүүлсэн байх тул уг алдааг намын дүрэмд засуулан авах нь зүйтэй гэж үзлээ.

2.2.3. Дүрмийн 12.15-д намын санхүүгийн тайланг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэхээс өмнө намын Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлсэн байхаар зааж, 8.20-д намын гүйцэтгэх төв байгууллага буюу Удирдах зөвлөл нь “Намын санхүүгийн нэгдсэн тайлан болон аймаг, нийслэл, дүүргийн намын хороо, намын бүтцийн байгууллага, нэгжийн ажлын тайлан, намын санхүүгийн тайланг хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт, үүрэг чиглэл өгөх” эрх, үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан.

2.2.4. Намын дарга болон Удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх үндэслэлийг 8.13-т, огцруулах үндэслэлийг 8.14-т тус тус зохицуулсан.

2.2.5. Дүрмийн 4.9-д “Намын гишүүний эрх”, 4.9.6-д “Намын гишүүнээс өөрийн хүсэлтээр түдгэлзэж болох ба түдгэлзүүлэх хүсэлтээ бичгээр гаргах бөгөөд түдгэлзэх хугацаа 4 жилээс ихгүй байна”, 4.9.7-д “Намын гишүүн нь төрийн албан хаагчаар томилогдсон, хуульд заасан үндэслэлээр намын гишүүнээс түдгэлзвэл зохих, албан тушаал хаах хугацаанд намын гишүүнээс хуулийн дагуу түдгэлзэнэ”, 4.9.8-д “Намын гишүүн нь гишүүнээс түдгэлзэх тухайгаа харьяалагдах тухайн шатны намын байгууллага /орон нутгийн болон намын төв байгууллага/-д албан ёсоор мэдэгдэж, намын гишүүний бүртгэлийн санд бүртгүүлнэ” гэж тусгасан байна.

2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн сонсох ажиллагааны явцад Эх орон намын дарга Б.Эрдэнэбатаас “... Хуулийн дагуу түдгэлзэх үндэслэл байвал намын гишүүн өөрийн хүсэлтийн дагуу түдгэлзэнэ. Харин намын зүгээс гишүүнийг түдгэлзүүлэхгүй тул “түдгэлзүүлэх” гэсэн заалтыг намын дүрэмд тусгаагүй, ... гишүүн өөрийн бүртгэлтэй байгаа намын салбар нэгжид түдгэлзэх хүсэлтээ гаргана” гэж тайлбарласныг дурдах нь зүйтэй.

2.2.6. Дүрмийн 9.20-д “Намын хороог дараах тохиолдолд татан буулгана. Үүнд: Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа удаа дараа ирүүлээгүй” гэж заасан.

2.2.7. Дүрмийн 6.8-д “Намын Их Хурал дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ. Үүнд: б. Намын Улс төрийн зөвлөлийг 11 гишүүний бүрэлдэхүүнтэй, ... байгуулж, бүрэлдэхүүнийг нь сонгож батлах, чөлөөлөх, огцруулах, нөхөн сонгох, ...”, 7.14-т “Намын улс төрийн зөвлөлийн хурлын бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөгдсөн гишүүдийн тоо Улс төрийн зөвлөлийн гишүүдийн гуравны нэг болсон тохиолдолд намын ээлжит бус Их хурлыг 30 хоногийн дотор зарлан хуралдуулж, Улс төрийн зөвлөлийн гишүүнийг нөхөн сонгоно” гэж төлөөллийн төв байгууллагын бүрэлдэхүүнийг нөхөн сонгох эрхийг Их хурлын онцгой бүрэн эрхэд хадгалуулсан нь хуульд нийцсэн байна.

2.2.8. Дүрмийн 14.1-д “Намын Их хурлын шийдвэрээр намыг өөрчлөн байгуулж, үйл ажиллагааг нь зогсоож болно. Энэхүү шийдвэрийг намын Их хурлын гишүүдийн дийлэнх олонхын саналаар гаргана”, 14.4-т “Намын үйл /ажиллагааг/ зогсоох шийдвэрийг намын Их хурлаас гаргасантай холбогдон байгуулагдсан комисс нь намын өр төлбөрийг барагдуулж дууссаны дараа үлдсэн хөрөнгийг Сонгуулийн төв байгууллагад шилжүүлнэ”, 14.5-д “Улсын дээд шүүхэд бүртгэгдсэн өдрөөс өөрчлөн байгуулах шийдвэр хүчин төгөлдөр болно” гэсэн зохицуулалтыг тусгасан.

2.2.9. Намын санхүүгийн асуудлыг хариуцсан дотоод аудиторыг нөхөн томилох бүрэн эрхийг намын Улс төрийн зөвлөл хэрэгжүүлэх талаар намын дүрмийн 7.4-т “Намын Улс төрийн зөвлөл нь жилд нэгээс доошгүй удаа хуралдаж дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд: ё. Удирдах зөвлөлөөс нэр дэвшүүлсэн намын дотоод аудиторыг томилох асуудлыг хэлэлцэн 4 жилийн хугацаатай батлах, чөлөөлөх, нөхөн томилох, улираан томилох, и. Удирдах зөвлөлийн гишүүн, намын дотоод аудиторын орон гарвал Удирдах зөвлөлөөс нэр дэвшүүлсэн саналыг хэлэлцэн нөхөн сонгох, батлах” гэж тус тус зохицуулсан байна.

Гурав. Сонсох ажиллагааны талаар:

3.1. Улсын дээд шүүхээс 2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр явуулсан сонсох ажиллагаанд Эх орон намын дарга Б.Эрдэнэбат, Ерөнхий нарийн бичгийн дарга И.Эрдэнэбат, намын ажилтан Т.Ганбат нар оролцож, намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийн дор дурдсан зохицуулалтыг дараах байдлаар тайлбарласан. Үүнд:

Дүрмийн 3.7-д “Нам нь бусад улс төрийн нам, олон нийтийн үүсгэл санаачилгын байгууллагуудын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж, гадаад улс орнуудын адил төсөөтэй бодлого бүхий улс төрийн намуудтай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ” гэсэн нь үзэл санаа нэгтэй улс төрийн хүчнүүдийн үйл ажиллагаанд оролцоно гэсэн агуулгатай;

Дүрмийн 4.10.7-д “Намын дүрмийг санаатай зөрчсөн, намын бодлого, үйл ажиллагаа, нэр хүнд, эв нэгдэлд хохирол учруулсан, намаас нэр дэвшиж УИХ болон нутгийн өөрөө удирдах байгууллагад сонгогдсоныхоо дараа өөр нам эвслийн бүлэгт шилжсэн, бүх шатны сонгуульд бие даан нэр дэвшсэн гишүүнийг намын гишүүнээс /бүртгэлээс/ хасах асуудлыг намын Удирдах зөвлөлөөс намын Хяналтын зөвлөлд уламжилж шийдүүлнэ” гэж заасан нь намын дүрмийг санаатай зөрчсөнийг ойлгох бөгөөд тухайн хүн улс эх орноосоо урвасан гэх зэрэг асуудлыг ноцтой зөрчилд хамааруулан ойлгоно;

Хяналтын зөвлөлийн маргаан шийдвэрлэх журам болон Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 19.4-т заасан журмыг болон 15 дугаар зүйлийн 15.2.6-д заасан “намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах журам”-ыг дүрэмд тусгаагүй тухайд “хуулийн үзэл баримтлал, агуулга санааг дүрэмдээ тусгаад, намын дүрэм бүртгэгдсэний дараа шаардлагатай журмыг батална” гэж;

Дүрмийн 6.8-д “Намын Их хурал дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ. Үүнд: ж.Намын Их Хурлын гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд хэлэлцэж буй асуудлаар хуралд оролцож буй гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргаж, тогтоол үйлдэнэ” гэж заасан нь техникийн алдаа байна. Дүрмийн 6.3-т Их хурал хамгийн багадаа 81 төлөөлөгч оролцож хуралдахаар заасан байхад 6.8.ж-д “дийлэнх олонх” гэсэн шаардлагагүй үг орсон байна” гэж;

Дүрмийн 6.8.ё-д “Намын Их хуралд тооллогын комисс байгуулан ажиллана. Тооллогын комисс нь Их хуралд оролцож буй гишүүдийн бүрэн эрхийг баталгаажуулна” гэсэн нь Их хурлын тогтоолоор баталгаажуулах ёстой зүйлийг “Тооллогын комисс” гэж алдаатай бичсэн. Тооллогын комисс бол саналыг тоолж, хяналтын тоог хурлынхаа тэргүүлэгчдэд өгөх үүрэгтэй” гэж;

Дүрмийн 7.4-т ““Намын Улс төрийн зөвлөл нь жилд нэгээс доошгүй удаа хуралдаж дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд: л.Намын бодлого, улс төрийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргах бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх” гэснийг Их хурлын онцгой эрхээс бусад асуудлыг шийдвэрлэнэ гэж ойлгоно” гэж;

Дүрмийн 8.12-т “Намын дарга нь дараах эрх, үүргийг эдэлнэ. Үүнд: а.Удирдах Зөвлөлийн хурлаар төрийн улс төрийн албан тушаалд нэр дэвшүүлэх, томилуулах

асуудлыг хэлэлцүүлэх” гэснийг төрийн өндөр албан тушаалд, аймгийн даргад нэр дэвшүүлэх гэх зэрэг асуудлыг;

Дүрмийн 8.13-т “Намын дарга болон намын Удирдах зөвлөлийн гишүүдийг дараах тохиолдолд чөлөөлнө. Үүнд: Нас барсан, эрүүл мэндийн шалтгаанаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан, ёс зүйн зөрчил гаргасан, намын бодлого, дүрэм, хууль тогтоомжийг удаа дараа зөрчсөн”, 8.24-т “Намын Удирдах зөвлөлийн гишүүнийг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө чөлөөлөх үндэслэл: Намаас гарсан; намын гишүүнээс түдгэлзвэл зохих төрийн албан тушаалд сонгогдсон, томилогдсон; Удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөх өргөдөл гаргасан; эрүүл мэндийн шалтгаантай” гэж заасан ба дүрмийн 8.13-т ерөнхий үндэслэлийг, 8.24-т илүү нарийвчлан зохицуулсан гэж;

Дүрмийн 8.25-д ““Намын Удирдах зөвлөлийн гишүүн чөлөөлөгдсөн, хугацаа дууссан, огцорсон тохиолдолд гишүүнийг нөхөн сонгох саналыг Улс төрийн зөвлөлд гаргаж шийдүүлнэ” гэсэн нь саналыг Удирдах зөвлөл өөрөө гаргахыг ойлгоно” гэсэн тайлбар гаргасныг дурдав.

3.2.Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагыг бүрдүүлэхдээ дараах шаардлагыг хангана:”, 8.2.1-д “нууц санал хураалт явуулах” гэж намын удирдах дээд болон төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллагыг нууц санал хураалтаар сонгож байгуулахаар хуульчилсан.

Эх орон намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийн 5.3-т “Намын удирдах дээд байгууллага нь намын Их хурал байна” гэж заасан тул Их хурлыг /төлөөлөгчдийг/ бүрдүүлэхдээ нууц санал хураалт явуулах хуулийн шаардлагыг хангах учиртай.

Тус дүрмийн 3.9-д “Намын бүтцийн, шат шатны байгууллагуудыг сонгож байгуулах, төрийн бүх шатны сонгуульд нэр дэвшүүлэх үйл ажиллагааг нууц санал хураалтаар явуулна” гэж намын бүтцийн болон шат, шатны байгууллагыг нууц санал хураалтаар сонгож байгуулах хуулийн шаардлагад нийцүүлэн баталсан байгаа боловч дүрмийн 6.3-т “Намын Их Хуралд намын нийт гишүүдээ төлөөлөн оролцохоо илэрхийлсэн намын гишүүд болон сонгуульт гишүүдийн саналыг нээлттэй ил тод авч 81-ээс доошгүй төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй хуралдана” гэжээ.

Эх орон намын дарга Б.Эрдэнэбатаас 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 1/51 дугаартай албан бичгээр “... Намын дүрмийн 6.3-т “Намын Их хуралд намын нийт гишүүдээ төлөөлөн оролцохоо илэрхийлсэн намын гишүүд болон сонгуульт гишүүдийн саналыг нээлттэй ил тод авч 81-ээс доошгүй төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй хуралдана” гэж заасан нь намын хуралд оролцох саналаа илэрхийлсэн гишүүд, сонгуульт гишүүдээс хяналтын тооны хүрээнд сонгогдсон төлөөлөгчдийг Их хурал зохион байгуулах ажлын хэсэг нээлттэй, ил тод бүртгэн авч, нууц санал хураалтаар бүрэн эрхийг нь баталгаажуулан мандат олгоно” гэсэн тайлбарыг ирүүлсэн болно.

Эх орон нам нь цаашид Их хурлын төлөөлөгчдийг бүрдүүлэхдээ санал хураалтаар төлөөлөгчдийг сонгон бүрдүүлэх тохиолдолд Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан ардчилсан зарчим, намын дүрмийн 3.9-д “Намын

бүтцийн, шат шатны байгууллагуудыг сонгож байгуулах, төрийн бүх шатны сонгуульд нэр дэвшүүлэх үйл ажиллагааг нууц санал хураалтаар явуулна” гэж заасны дагуу нууц санал хураалтаар шийдвэрлэхийг анхаарах нь зүйтэй.

Дөрөв.Бусад асуудлын тухайд:

Улсын дээд шүүхэд гаргасан өргөдлийг шалгах ажиллагааны явцад тус намаас 2026 оны 03 дугаар сарын 30, 2026 оны 04 дүгээр сарын 07, 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдрүүдэд намын дүрмийн зарим заалтыг хэрхэн ойлгох утгыг болон намын дүрэмд “Их хурал” гэж бичих ёстойг “Бага чуулган” гэж андууран бичиж техникийн шинжтэй алдаа гаргасан зэрэг асуудлыг тайлбарлаж, бичгээр тайлбар ирүүлсэн байх тул 2026 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит бус Их хурлаар хэлэлцэн баталсан намын дүрэмд бичигдсэн үг, үсгийн алдааг хянаж, ирүүлсэн тайлбарын дагуу засварлан ёсчилж, Улсын дээд шүүхэд ирүүлэх шаардлагатай.

Эх орон намын 2026 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит бус Их хурлаас баталсан намын дүрэм /Шинэчилсэн найруулга/ нь Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгасан, бүртгэхээс татгалзах ноцтой зөрчил байхгүй тул бүртгэж шийдвэрлэв.

Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.5 дахь хэсгийг баримтлан Эх орон намын дүрэм /Шинэчилсэн найруулга/-ийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Г.БАНЗРАГЧ